

*“Ялагчид төгс биш.
Тэдний цорын ганц ялгаа нь
өрсөлдөгчөөсөө бага
алдаагаргадаг”*

*Монгол Улсын Ерөнхийлөгч
Цахиагийн Элбэгдорж*

*Win Win
technique*

101

*Цэвэр
ялалт*

101



*Улс төрийн сонгуулийн кампанит ажлын
Захиалгат багц сургалт*

*Цэвэр
ялалт
101*



EVI THINK TANK INSTITUTE

*Улс төрийн сонгуулийн кампанит ажлын
Захиалгат багц сургалт*

*Улс төрийн
сонгуулийн
кампанит ажил*

Сургалтын танилцуулга
Сургалтын хөтөлбөр
Холбогдох материал
EVI хүрээлэнгийн тухай

Улс төрийн сонгуулийн кампанит ажлын
Захиалгат багц сургалт

Улс төрийн тогтолцооны нэгэн чухал үйл явц бол чөлөөт, ардчилсан сонгууль мөн. Коммунист дэглэмээс ардчилалд шилжих үйл явц эхэлснээс хойш 20 жил болж буй манай улсад парламентын тав, орон нутгийн тав, ерөнхийлөгчийн таван удаагийн сонгууль болж өнгөрчээ. Өнгөрсөн сонгуулиудын явцаас харахад сонгуулийн кампанийн үеэр сонгогчдыг мөнгөөр худалдан авах, төрийн алба, албан хаагчдыг ашиглах, сонгогчдын өгсөн саналыг будлиантуулах зэрэг хууль зөрчсөн үйлдэл удаа дараа гарах болсноос олон нийтийн дунд сонгуульд үл итгэх байдал газар авч, нийт иргэдийн ардчилсан сонгуулийн талаарх үнэлгээ буурч байна. Иргэдийн оролцоо жил ирэх тутам буурсаар 2008 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуульд хамгийн бага түвшинд хүрлээ. 2008 оны 6 дугаар сарын 29-нд болсон парламентын ээлжит сонгуулийн үр дүн будлиантай болсны улмаас үүссэн 2008 оны 7 дугаар сарын 1-ний үймээн нь дарангуйлагч дэглэмээс ардчилалд тайван замаар амжилттай шилжсэн Азийн цорын ганц улс гэгдэх монголын түүхэнд гарч байгаагүй хар үйл явдал болсон юм. Сонгуулийн үйл явцыг судлах нь нэгэн зэрэг улс төрийн намуудын төлөвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн улс төрийн боловсрол, иргэний соёл зэрэг аливаа улсын ардчиллын гол үзүүлэлтүүдийг тогтоох боломжийг олгодог тул судалгааны болон практикийн ихээхэн ач холбогдолтой билээ. Монголд сонгуулийн систем, сонгуулийн эрх зүйн орчин, сонгогчдын зан үйлийн талаар судалгаа нэлээд хийгдсэн байдаг боловч сонгуулийн кампанийн хэв маяг, улс төрийн намуудын сонгуулийн стратеги, үйл ажиллагааны талаар судалгаа хараахан хийгдээгүй байна.

Сүүлийн сонгуулиудад нийтлэг ажиглагдаж байгаа хоосон амлах, сонгогчдын саналыг худалдан авах, хулгайлах зэрэг нэр дэвшигч хийгээд улс төрийн намуудад байж боломгүй, ёс зүйгүй үйлдэл гарах болсон нь сонгогчдын итгэл сэтгэлээр тоглосон, иргэний сонгох, сонгогдох эрхийг зөрчсөн үйл явдал болж байна. Сонгогчид өөрсдийн төлөөллөөр нийгмийн ирээдүйг цогцлоон бүтээх манлайлагчдыг сонгодог. Сонгогчид цэвэр ялалтыг ёс зүйтэй бүх улстөрчөөс хүлээж байна. Та бохир ялагчийн нэг бүү байгаасай, сонгуулийн дараах сонгогчдын **хоржоонтой** ярианы эзэн нь бүү болоосой гэж хүссэн учраас бид танд туслахыг зорьлоо. Нөгөө талаас орон нутгийн нөхцөл байдлыг сайтар мэдэхийн хувьд та улс төрийн туршилагадаа тулгуурлан амжилтад хүрэхүйц кампанит ажлын төлөвлөгөө боловсруулахдаа биднээс сурсан бүхий л зүйлээ чөлөөтэй авч ашиглахыг зөвлөж байна. Сургалтаар дурдсан сайн туршилага, жишээнүүдээс кампанит ажилдаа хөрвүүлэн ашиглах боломж ч танд нээлттэй.

Сургалтын зорилго: Сонгууль бол хүн бүрийн стратеги тоглолтын үр дүн юм. Сонгуульд нэр дэвших нь улс төрийн тэмүүллийн үр дагавар тул сонгуулийн арга, техникийг нийгмийн болоод бизнесийн байр сууриа эзлэх, хүсэл тэмүүлэлдээ хүрэх тэрхүү зорилгодоо ашиглах хэрэгтэй юм. Улс төрийн сонгуулийн кампанит ажилд төдийгүй нийтийг хамарсан төрөл бүрийн кампанит ажлыг зохион байгуулахад энэхүү технологийн шийдлүүдээс зөвийг нь олж кампанит ажилдаа хэрэглэх, энэ арга технологийг эзэмшүүлэхэд сургалтын зорилго оршино.

Сургалтын ач холбогдол: АНУ-ын “Leadership Institute”, Laurus Group, Мариланд, Ютагийн их сургуулийн эрдэмтэй, доктор, профессорууд, Монголын “EBI Think Tank” хүрээлэн хамтран энэхүү сургалтын гарын авлагыг болорвсруулсан ба сургалтаас та бүхэн ач холбогдол өндөртэй, үр дүнтэй, цаашдаа байгууллагадаа хэрэгжүүлж болох олон санал санаачлагыг мэдэрч, хувь хүнийхээ хувьд хурдан хугацаанд эргэлт хийн удирдагчийн манлайлал болоод бүтээлч сэтгэлгээ, шинийг санаачлах чадварыг эзэмших болно. Сургалтыг асуудалд тулгуурласан сургалтын арга хэлбэрээр явуулна. Тараах материалаар хангахгүй ба тухайн сургалтанд оролцсон хүн өөрийн тэмдэглэгээг сайтар хийх боломжоор хангана. Хичээлийн үндсэн агуулга нь power point хэлбэрээр суралцагдын гар дээр файлаар очно. Сургалтын цагийг нягт баримталсан, амжилттай дүүргэсэн хүн бүрт АНУ-ын Манлайллын Хүрээлэн, EBI хүрээлэнгийн Манлайллын сургалтын сертификат гардуулна.

Сургалтанд өгөх материал: Цэвэр ялалт ном

Сургалт явагдах хугацаа:

Захиалга өгч байгаа улс төрийн нам, нэр дэвшигчтэй тохиролцож хугацааг сонгоно.

Улс төрийн сонгуулийн кампанит ажлыг
амжилттай удирдан зохион байгуулах нь
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Сургалтын эхний өдөр:

09:00 – 09:20	Сургалтын нээлтийн ажиллагаа
09:20-11:00	Сонгуулийн хуулийн төслийн хэлэцүүлэг
11:00-11:30	Цайны завсарлага
12:00-13:00	Бүлгээр ажиллах: Сонгуулийн кампанит ажлын мессеж гаргах
13:00-14:00	Үдийн хоол
14:00-15:00	Сонгуулийн кампанит ажлын бүтэц ба кампанит ажлын баг. Сайн дурын ажилтнуудын сонгуулийн кампанит ажилд татан оролцуулах нь
15:00-16:00	Сонгуулийн кампанит ажлын стратеги ба тактик
16:00-16:30	Цайны завсарлага
16:30-17:30	Бүлгээр ажиллах: Сумын түвшинд хэрэгжүүлэх сонгуулийн стратегийн чиг хандлагыг тогтоох нь
17:30-18:30	Сонгуулийн кампанит ажлын мессеж ба стратеги : Бүлгүүдийн танилцуулга

Сургалтын хоёр дахь өдөр:

09:00-11:00	Сонгуулийн кампанит ажилд хэвлэл мэдээллийн хэрэгслэлийг хэрхэн ашиглах, олон нийтийн мэдээллийн өмнө гарч үг хэлэх нь
11:00-11:30	Цайны завсарлага
11:30-12:10	Хэвлэлийн бага хурал зохион байгуулах, хэвлэлийн мэдээ бэлтгэх, өөрийн мессеж, уриаг сонгогчдод зөв хүргэх нь
12:10-13:00	Бүлгээр ажиллах: Бүлгүүд хэвлэлийн бага хурал зохион байгуулна.
13:00-14:00	Үдийн хоол
14:00-15:00	Өрсөлдөгчтэй ажиллах техник
15:00-16:00	Сонгуулийн кампанит ажлын зар сурталчилгааны материалд өртөг бага зарцуулах боломжууд

16:00-16:30 Цайны завсарлага
16:30-17:00 Хөрөнгө босгох техникүүд
17:30-18:30 Бүлгээр ажиллах: Кампанит ажилд хөрөнгө босгох

Сургалтын гурав дахь өдөр:

09:00-10:00 Сонгуулд санал авах нөхцөл байдалд анализ хийх нь: Сонгогчдыг ангилах техник
10:00-11:00 Олон нийтийн харилцаа ба имиж бүрдүүлэх нь
11:00-11:30 Цайны завсарлага
11:30-12:30 Сонгуулийн кампанит ажлын төвлөлт
12:30-13:30 Бүлгээр ажиллах: Кампанит ажлын төлөвлөгөө боловсруулна

13:30-14:30 **Үдийн хоол**

14:30-15:30 Сонгуулийн санал хураах өдрийн үйл ажиллагаа
15:30-16:30 Оролцогчид ТВ камерын өмнө хөтөлбөрөө танилцуулах нь
16:30-17:30 Үргэлжлэл
17:30-18:40 Үнэлгээ
18:40-19:00 ТӨГСӨЛТ

EVI THINK TANK INSTITUTE

*Улс төрийн сонгуулийн кампанит ажлын
Захиалгат багц сургалт*

*Улс төрийн
сонгуулийн
кампанит ажил*

EVI THINK TANK INSTITUTE

*Улс төрийн сонгуулийн кампанит ажлын
Захиалгат багц сургалт*

*Улс төрийн
сонгуулийн
кампанит ажил*